



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 4-149

Улаанбаатар хот

Малын тэжээлийн хангамжийг
сайжруулах арга хэмжээг зохион байгуулах тухай

Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор баталсан "Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам"-ын 4.2, 4.3, 4.4 дэх заалт, Малын тэжээл импортлох, түгээх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэл, мөн өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвс, тэжээл импортлох болон дотооддоо үйлдвэрлэн малчид, фермерүүдэд нийлүүлэх сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрт олгох санхүүжилтийн дээд хязгаарыг нэгдүгээр, шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүдтэй хэлцэл хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нэгдүгээр хавсралтад дурьдсан аж ахуйн нэгжүүдтэй хэлцэл хийж гэрээний гол болон бусад нөхцлийг урьдчилан тохирохыг ажлын хэсэг /Л.Чой-Иш/-т, бодлогын гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулгад тус тус үүрэг болгосугай.

3. Барьцаа хөрөнгийн шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээний нөхцлийн дагуу 2018 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хүүгүй зээлийн гэрээ байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д даалгасугай.

4. Зээл олгоход шаардагдах 40.000.000.000 /дөчин тэрбум/ төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-144 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын 2.32-д заасан зардлаас санхүүжүүлэхийг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д зөвшөөрсүгэй.

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2017 оны 11 дүгээр сарын 16-ны
өдрийн А.149 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЗЭЭЛД ХАМРАГДАХ АЖ АХУЙН НЭГЖҮҮД

№	Аж ахуйн нэгжийн нэр	Санхүүжилт /төгрөг/
1	Түмэн шувуут ХХК	1 000 000 000
2	Милл хаус ХХК	2 000 000 000
3	Од групп ХХК	3 000 000 000
4	Дөлгөөн оргил ХХК	1 200 000 000
5	Туртелком ХХК	1 000 000 000
6	Аянжин ХХК	450 000 000
7	Асгат кент ХХК	1 000 000 000
8	Биохэлф монголиа ХХК	1 000 000 000
9	Арованна ХХК	5 000 000 000
10	Архалиун цамхаг ХХК	750 000 000
11	Хархираан хөгжил ХХК	600 000 000
12	Эйч Эс Эм ХХК	1 000 000 000
13	Жинст транс ХХК	1 300 000 000
14	Ийст вест ресурс ХХК	1 100 000 000
15	ЧМТО ХХК	2 000 000 000
16	Бор банди групп ХХК	190 000 000
17	Эрхжин ХХК	650 000 000
18	Галин интернэшнл ХХК	1 200 000 000
19	Ондилт ХХК	500 000 000
20	Чансаа ханхөхий холдинг ХХК	3 000 000 000
21	Бадрангуй орших ХХК	1 000 000 000
22	Энсада тракторон ХХК	1 000 000 000
23	Хөвсгөл алтан дуулга ХХК	5 000 000 000
24	Пепмайнд ХХК	500 000 000
25	Жи Өү Ти Ти ХХК	2 000 000 000
26	Нисэг агро ХХК	700 000 000
27	Мөрөн агро ХХК	160 000 000
28	Хийморлиг эрчүүдийн хүч ХХК	1 200 000 000
29	Батдэлгэр трейд ХХК	500 000 000
НИЙТ		40 000 000 000